



## УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2019 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/114

Улаанбаатар хот

### Аян зохион байгуулах тухай


Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн "Хөрс хамгаалах өдрийг тэмдэглэх тухай" 2017 оны 66 дугаар тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны "Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцыг дүгнэх, 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай" 19/16 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт, бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Нийслэлийн Засаг даргын 2019 оны "Хот нийтийн аж ахуйн чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 03 дугаар албан даалгавар, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэдэд хөрсний бохирдлын талаар мэдээлэл сурталчилгаа хүргэх, нүхэн жорлонгийн стандартыг танилцуулах, хотын суурьшлын бүсийн хөрсний бохирдлыг бууруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой "Эрүүл хөрс-Эрүүл орчин" аяныг 2019 оны 04 дүгээр сарын 27-оос 2019 оны 10 дугаар сарын 01 хүртэлх хугацаанд зарласугай.

2. Аяныг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар байгуулсугай.

3. Аяныг зохион байгуулах удирдамж, аяны хугацаанд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг тус тус боловсруулан батлуулж, хэрэгжүүлж ажиллахыг Ажлын хэсэгт даалгасугай.

4. Батлагдсан удирдамж, төлөвлөгөөний дагуу аяныг нутаг дэвсгэртээ аяны үйл ажиллагааг зохион байгуулж, олон нийтэд сурталчилж ажиллахыг Дүүргүүдийн Засаг дарга нарт, зуслан ногоон бүсийн айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудад аяны талаарх мэдээлэл өгч, сурталчлахыг Нийслэлийн Байгаль орчны газар /Э.Баттулга/-т, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тохжилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т тус тус үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



D:\backup\_old\_pc\Work documents\doc 2019\Тушаал doc.docx

• 1110300363

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн  
2019 оны 04 сарын 23  
өдрийн 1111 тушаалын хавсралт



“ЖОРЛОНГОО ӨӨРЧИЛЖ- ХӨРСӨӨ ХАМГААЛЪЯ” АЯНЫГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн дарга: Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны  
Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга

Ажлын хэсгийн гишүүд: Баянгол дүүргийн Засаг даргын орлогч  
Баянзүрх дүүргийн Засаг даргын орлогч  
Сүхбаатар дүүргийн Засаг даргын орлогч  
Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын орлогч  
Хан-Уул дүүргийн Засаг даргын орлогч  
Чингэлтэй дүүргийн Засаг даргын орлогч  
Багануур дүүргийн Засаг даргын орлогч  
Багахангай дүүргийн Засаг даргын орлогч  
Налайх дүүргийн Засаг даргын орлогч  
Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Эрүүл  
ахуй халдвар, хамгааллын хяналтын улсын ахлах  
байцаагч  
Нийслэлийн Байгаль орчны газрын дарга  
Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд дарга

Нарийн бичгийн дарга: Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны  
Тусгай хог хаягдал хариуцсан мэргэжилтэн